

Ойн олон талын үр ашиг

2015 оны 11 сар

Хавир Де Ламо
НУБОХ - ДДХМТ

Экосистемийн үйлчилгээ: Экосистемээс хүртэх үр ашиг

- Экосистемийн үйлчилгээ бол хүмүүс экосистемээс олж авах үр ашиг юм. Дараахь зүйлс хамаарна:
 - **Бүтээгдэхүүний хангамж:** мөнгөөр хэмжигдэх материаллаг зүйлс орно (мод түлээ, гуалин)
 - **Зохицуулах ба дэмжих үйлчилгээ:** Байгалийн үр ашиг нь экосистемийн тэнцвэрт байдлаас үүсэх байгальд үзүүлэх үр ашиг (уур амьсгалыг зохицуулах)
 - **Соёлын үйлчилгээ:** амралт, сувилал, аялал жуулчлал, гоо зүйн болон шашны чиглэлийн үр ашгууд хамаарна;
(Мянганы хөгжлийн зорилтын экосистемийн үнэлгээ , 2005)



Ойгоос хүртэх хүрээлэн буй орчны үр ашиг нь юу байх вэ?

Ой нь дэлхий ертөнцийн бусад экосистемүүдээс илүү олон чухал цогц үр ашгийг өгч байдаг. Ойн бүтээгдэхүүн, ойн үйлчилгээ зэрэг нь хүмүүст янз бүрийн замаар үр ашгаа өгч байдаг.


Ойн чухал бүтээгдхүүнүүд

ГУАЛИН: Дэлхий дээр ойгоос авч байгаа гуалин эдийн засгийн маш чухал бүтээгдэхүүн байсаар байна.

ТҮЛШНИЙ МОД: Дэлхийн тодорхой хэсэгт эрчим хүчийг биомассаас гарган авч байна.

ОЙН ДАГАЛТ БАЯЛАГ: Хоол хүнс, эмийн ургамал, зөгийн бал, г.м олон бүтээгдэхүүн авч хэрэглэж байна.

- Монголд хушны самар, жимс, эмийн ургамал зэргийг ойгоос авч ашигладаг
- Индонезийн Суринамед 7-8 төрлийн чухал эмийн ургамлыг ойгоос түүж бэлтгэдэг байна. (Van Andel & Havinga, 2008).




Ойгоос хүртэх хүрээлэн буй орчны үр ашиг нь юу байх вэ?

ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Ой нь усны горим зохицуулах, усны чанар, усны хэмжээнд тодорхой нөлөө үзүүлдэг.

Ой нь газрын доорх ба газрын дээрх экосистемийн ус, чийгийн эх үүсвэр болдог. Амазонд гэхэд хур тунадасны 60% - нь газрын дээрх экосистемийн ууршилтаас үүсдэг. (MEA 2005)

- Хур тунадасны ус хөрсөнд шингэж уст давхаргын усны эх үүсвэр болоход тусална.
- Эгц, налуу газрын хөрс үерийн усанд урсаж хөрс гэмтэхээс болон үерийн давтамжийг бууруулахад тусална.



Ойгоос хүртэх хүрээлэн буй орчны үр ашиг нь юу байх вэ?

ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

ХӨРСНИЙ ЭЛЭГДЛЭЭС ХАМГААЛАХ

Ой нь хөрсний бүтцийг сайжруулах, хөрсний бат бэх байдлыг нэмэгдүүлж хөрсний нуралт, гулгалтыг багасгана.

- Монгол орны заган ой нь элсний нүүлт, шороон шуургын нөлөөг багасгах ач холбогдолтой.
- Хятадын Занжиажи Үндэсний Паркад хөрсний гулгалтаас болж жилд 2.77 сая.тн хөрсний шилжилт болдог байна.

(Zhao et al., 2009)



Ойгоос хүртэх хүрээлэн буй орчны үр ашиг нь юу байх вэ?

ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- Ой нь нүүрстөрөгчийг шингээгч: Агаар мандлаас нүүрсхүчлийн хийг шингээдэг.
 - Газар дээрх нүүрстөрөгчийн 45% -нь дэлхийн ойн бүрхэвчид хуримлагдана. (NASA, 2012)
- Ой нь хур тунадас ба агаарын температурыг зохицуулж уур амьсгалын үйлчилгээ үзүүлдэг.
 - Сүүдэрлэх болон хоргодох газар болж өгдөг.
- Ой нь агаар мандалыг эрүүлжүүлэх болон хортон шавжтай тэмцэх үйлчилгээ үзүүлдэг.
 - Ойтой газарт 400м радиуст шувууны томуу болон бусад халдварыг багасгадаг байна. (Mendenhall et al., 2013).



Ойгоос хүртэх нийгэм, соёлын үр ашиг нь юу байх вэ?

“Материаллаг бус соёлын, амралт зугаалгын, шашин шүтлэгийн үр ашиг үзүүлнэ”

- Ой нь эко аялалыг хөгжүүлэхэд тусална.
 - Ой болон ТХГН –нь жуулчдын үргэлж очих дуртай газар байдаг. Тухайлбал зэрлэг ан амьтан агнах, шувуу харах, явган болон морин аялал хийх г.м
- Ой нь шашны үйл ажиллагаа, амралт зугаалгаар явах болон ариун дагшин, онгон байгаль үзүүлэх зэргээр соёлын чухал ач холбогдолтой.
- Ой нь тохитой тухтай орчныг бүрдүүлнэ.
 - Ойтой ойр амьдрахад аятай тухтай тохилог орчин бүрдэнэ.




Газарзүйн байдлаас шалтгаалсан олон талт үр ашиг


Зарим газар нутаг/ Зарим төрлийн ойгоос
илүү чухал үр ашиг үзүүлдэг.

Жишээ нь:
Панамын ойн
үр ашиг


Биомассын нүүрстөрөгчийн хуримтлал




Биолог ийн олон янз байдлыг хадгалахад густай



Аялал жуулчлалд чухал



Хөрсний гулгалтаас хамгаалахад чухал



Дүгнэлт: Ойн олон талын үр ашиг

- Ой нь нийгэм, хүрээлэн буй орчны болон бусад чухал ач холбогдолтой экосистемийн үйлчилгээ үзүүлдэг.
- Эдгээр үр ашгийг өгч чадах чухал газрууд нь газрын төрх байдлаасаа хамаараад ялгаатай байдаг.
- REDD+ -ийг маш сайн төлөвлөж хэрэгжүүлбэл олон талт үр ашгийг нэмэгдүүлж эрсдлийг бууруулахад тусална.



Баярлалаа!

xavier.delamo@unep-wcmc.org

